



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкинд автомашин нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: Б -2018/2

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан жийп ангиллын автомашин нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жил: 2014, 2015, 2016 он

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгох үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 40 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,  
Монголбанкны “А” байрны 1 давхар, 2 тоот өрөө,  
Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471

